



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар 18

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арвангуравдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нийт 27,210,000 /хорин долоон сая хоёр зуун арван мянга/ төгрөгийн балансын үнэтэй үлдэгдэл өртөггүй 3 ширхэг тээврийн хэрэгслийг хавсралтын дагуу акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Ш.Мөнх-Оргил)-д дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Актлах хөрөнгийг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор акталж, устгах;

2.2 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3 Тогтоолын биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх;

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2023 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн
18 дугаар тогтоолын хавсралт



Цагаандэлгэр сумын Засаг даргын Тамгын газрын актлах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Сери	Дугаар			Арлын дугаар	Моторын дугаар	Моторын эзлэхүүн /см3/			
1	Трактор /Тусгай зориулалт/		-	-	2008	2008-12-31	MC02587845			1,910,000	1,910,000	0
2	Трактор /Тусгай зориулалт/		-	-	2010	2012-05-29				5,300,000	5,300,000	0
3	Фермер автомашин	УАЗ-220692-033	ДУА	72-48	2012	2012.07.09	В0466039	В0005080	2890	20,000,000	20,000,000	0
Хөрөнгийн нийт дүн										27,210,000 /хорин долоон сая хоёр зуун арван мянга / төгрөг		